



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 1/13

Улаанбаатар хот

Сонгуулийн тойрог байгуулах, тойрогт
ногдох мандатын тоо, дугаар, нутаг
дэвсгэр, төвийг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4.1 дэх заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XXVI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 1 дүгээр тойргийг 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрээр, 2 дугаар тойргийг 2 дугаар хорооны нутаг дэвсгэрээр тус тус тогтоосугай.

2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төв, тойрогт ногдох мандатын тоог хавсралтаар баталсугай.

3. Тогтоолыг хуулийн хугацаанд Сонгуулийн Ерөнхий хороо, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус хүргүүлэхийг Хурлын Ажлын алба (М.Давааням)-нд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
113 дугаар тогтоолын хавсралт



СОНГУУЛИЙН ТОЙРОГ, ТОЙРОГТ НОГДОХ МАНДАТЫН ТОО,
ДУГААР, НУТАГ ДЭВСГЭР, ТӨВИЙН ТОО

Тойргийн дугаар	Тойргийн нутаг дэвсгэр	Тойргийн төв	Мандатын тоо
1	1 дүгээр хороо	Засаг даргын Тамгын газар	14
2	2 дугаар хороо		11